

MOSCAP Гишүүнчлэлийн удирдамж

Энэ удирдамж (түүнд цаашид орох нэмэлт өөрчлөлтүүд) нь Монголын зохиолч, хөгжмийн зохиолч, нийтлэгчдийн нийгэмлэгийн *үндсэн дүрэм* болон *гишүүнээр элсэх өргөдлийн маягт*, бүтээл мэдүүлэх маягт, *гишүүн эрхээ шилжүүлэх гэрээнд* заасан нөхцөлүүдийг нэмж тодруулж буй бөгөөд гишүүнчлэлийн үндсэн нөхцөл нь эдгээр баримт бичигт хамт тусгагдсан болно. Мөн энэ удирдамжийг цаг хугацааны явцад өөрчилж болно. Өөрчлөлт хийгдвэл Гишүүдэд мэдэгдэнэ, мэдэгдсэн даруйд тухайн өөрчлөлт хүчин төгөлдөр болно.

Гишүүн нь энэхүү удирдамж, Нийгэмлэгийн дүрэм, нийгэмлэгт эрхээ шилжүүлэх гэрээний заалт, зохиогчийн эрхийн тухай хууль дүрмийг зөрчсөн, гишүүнчлэлд тавигдах шаардлагыг хангаагүй болох нь баримтаар нотлогдсон тохиолдолд MOSCAP Гишүүнчлэлийг цуцлах эрхтэй.

Нийгэмлэгийн дүрэм дэх гишүүнчлэлийн үндсэн нөхцлүүд

1. Нийгэмлэгийн зорилго, үйл ажиллагааны чиглэл, үндсэн дүрэм, гишүүн эрхээ шилжүүлэх гэрээний нөхцлүүд, бүтээл ашиглалтын тариф ба лицензийн орлого хуваарилах журмыг хүлээн зөвшөөрч дэмжсэн дотоод гадаадын уран бүтээлчид, иргэн, байгууллага нийгэмлэгт гишүүнээр элсч болно.
2. Гишүүн элсэх өргөдлөө Удирдах зөвлөлийн хурлаас батлагдсан маягтын дагуу бичгээр гаргана.
3. Гишүүн элсэх өргөдлийг нийгэмлэгийн гэрээ эрхийн асуудал хариуцсан ажилтан хүлээн авч, бүртгэн, зохиогчийн эрх шилжүүлэх гэрээ хийж, гишүүнээр элсүүлэх асуудлыг удирдах зөвлөлд танилцуулан шийдвэрлүүлж, гишүүн өөрөө бүтээлийн мэдүүлэг бөглөж, бүтээлээ бүртгэл мэдээллийн санд бүртгүүлнэ.
4. Гишүүн нас барсан тохиолдолд түүний гэрээслэлээр буюу хууль ёсны өв залгамжлагч нь нийгэмлэгийн гишүүн болох эрхтэй. Гишүүн нас барсан оноос хойш гурван жил өнгөрсний дараа түүний өв залгамжлагч тогтоогдоогүй бол гишүүний эрхийг цуцална.

Нийгэмлэгийн гишүүний эрх үүрэг

5. “Зохиогчийн эрхийн тухай хууль”-д заасны дагуу зохиогчийн эрх эзэмшигчийн эрх шилжүүлэх гэрээгээр Нийгэмлэгт бүтээл ашиглуулах онцгой эрхээ олгох бөгөөд гишүүнчлэлийн гэрээний хүчинтэй хугацаанд MOSCAP-тай байгуулсан гэрээний эрх үүргээ нийгэмлэгийн дүрмийн 3.1.8-д зааснаас бусад нөхцөлд өөр этгээдэд шилжүүлэхгүй.
6. Бүтээл ашиглуулах лицензийн гэрээг гуравдагч этгээдтэй байгуулсан болон бүтээл ашиглах онцгой эрхээ бусдад бүрэн ба хэсэгчлэн шилжүүлсэн бол нийгэмлэгт нэн даруй мэдээлэх,
7. Жил бүр бүх гишүүдийн хуралдаа идэвхтэй оролцож, нийгэмлэгийн шийдвэрийг дагаж мөрдөх, зохиогчийн эрх эзэмшигчийн төлөөлөх эрх олгох зөвшөөрлийн гэрээ, бүтээл ашиглалтын төлбөрийн хэмжээ, лицензийн төлбөр цуглуулах хуваарилах журамд саналаа өгөх,
8. Гишүүн одоо байгаа болон ирээдүйд туурвих хөгжмийн бүтээлээ нийгэмлэгт бүртгүүлэх үүрэгтэй ба бүтээлийн жагсаалтын өөрчлөлт шинэчлэлтийг жил бүр болон тухай бүр өгч, бүтээлээ ашиглуулсны төлбөрийг нийгэмлэгийн хуваарилалтын журамд заасны дагуу авах,
9. Удирдах зөвлөлөөс тухайн жилд баталсан гишүүнчлэлийн жилийн төлбөр ба элсэлт бүртгэлийн хураамж төлөх,

10. Бүтээл ашигласны төлбөр хуваарилалтын талаарх санал гомдлоо Хяналтын зөвлөлд гаргаж, шалгуулах,
11. Нийгэмлэгийн үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, бүтээл ашиглалтын батлагдсан тариф, төлбөр хуваарилалтын журам, өөрийн бүтээлийн ашиглалтын талаарх мэдээллийг шаардаж танилцах эрхтэй ба бусад гишүүний зөвшөөрөлгүй бусад гишүүний төлбөр хуваарилалтыг харах эрхгүй
12. Нийгэмлэгийн удирдах зөвлөлийн дарга ба гишүүдийг сонгох, сонгогдох санал өгөх, нийгэмлэгийн үйл ажиллагааны талаар санал гаргах, хяналт тавих, гишүүнчлэлээс татгалзах эрхтэй.
13. Гишүүнчлэлээс татгалзах хүсэлтээ өөрөө бичгээр гаргасан тохиолдолд гишүүний эрхийг цуцалж, хүсэлт гаргаснаас 6 сарын дараа эрх ашгийг дуусгавар болгоно. Гишүүний эрх цуцлагдсанаас 6 сарын хугацаанд бүтээл ашиглалтын тайланд үндэслэн өөрийн бүтээл ашиглалтын төлбөрөө авах эрхтэй. 6 сараас хойших хугацааны бүтээл ашигласны орлогыг нийгэмлэгийн “Нөөц сан”-д төвлөрүүлж, бүтээл ашиглалтын хуваарилалтын журмаар зохицуулна.
14. Өөрийн бүтээлийг хууль бусаар ашиглаж байгаа талаарх мэдээлэлийг баримтжуулан өгч, хуульд заасны дагуу арга хэмжээ авахуулах хүсэлт гаргах
15. Нийгэмлэгийн дүрэм, ерөнхий чуулган, бүх гишүүдийн хурал, удирдах зөвлөлийн хурлаас гарсан тогтоол шийдвэрийг дагаж мөрдөх ба нийгэмлэгийн нэр хүнд болон хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах

MOSCAP Гишүүнчлэлийн шалгуур

Зохиогч гишүүнд тавигдах шаардлага

1. Монгол Улсын иргэн бөгөөд хөгжмийн зохиолч, яруу найрагч, дууны үг ая зохиогч, rapper, beat maker, үүсмэл бүтээлийн хөгжмийн найруулагч
2. Дор хаяж нэг 1 бүтээл зохиосон, бүтээл нь 2-оос дээш минутын үргэлжлэх хугацаатай ба дараах нөхцлүүдийн **аль нэгийг** хангасан байна.
 - Сүүлийн **1 жилийн** хугацаанд тоглолт арга хэмжээ дээр арилжааны зорилгоор дор хаяж 3 удаа тоглогдсон байх;
 - Кинонд бичигдэн бичлэг хийгдсэн байх;
 - Сүүлийн **1 жилийн** хугацаанд аль нэг телевиз, радиогоор дор хаяж 3 удаа нийтэд дамжуулсан байх; эсвэл
 - 1 дижитал стриминг эсвэл 1 видео платформ дээр арилжааны зорилгоор нийтэд дамжуулсан бөгөөд дор хаяж 1,000 сонсолт/үзэлттэй байх.
 - Зар сурталчилгааны богино ая Jingle зохиогчийн хувьд: сурталчилгаа эсвэл бусад арилжааны зориулалтаар ашиглагдсан, нийт хугацаа нь дор хаяж 60 секунд байх 1 буюу түүнээс дээш аятай байх;

Жич: Хэрэв хөгжмийн нийтлэгчид эрх шилжүүлсэн Publishing гэрээтэй бол, гэрээний хуулбарыг ирүүлэх нууцлалтай мэдээллийг халхалж, хасаж болно.

Өв залгамжлагч гишүүнд тавигдах шаардлага

1. Монгол Улсын иргэн бөгөөд бүтээл ашиглах эд хөрөнгийн онцгой эрхийг Иргэний хуульд заасан журмын дагуу өв залгамжилснаа нотариатаар баталгаажуулсан байх
2. Эрх эзэмшиж буй бүтээл нь дараах нөхцлүүдийн аль нэгийг хангасан байна.
 - Сүүлийн **1 жилийн** хугацаанд аливаа тоглолт, арга хэмжээ дээр арилжааны зорилгоор дор хаяж 3 удаа тоглогдсон байх;
 - Кинонд бичигдэн бичлэг хийгдсэн байх;

- Сүүлийн **1 жилийн** хугацаанд аль нэг телевиз, кабелийн суваг **эсвэл** радиогоор дор хаяж 3 удаа нийтэд дамжуулсан байх;
- Нэг дижитал стриминг **эсвэл** видео платформ дээр арилжааны зорилгоор нийтлэгдсэн бөгөөд дор хаяж нэг мянга 1,000 **сонсолт/үзэлттэй** байх.

Хөгжмийн нийтлэгч паблишер гишүүнд тавигдах шаардлага

МУ-ын хууль тогтоомжийн дагуу бүртгэлтэй ААН, хөгжмийн паблишинг үйл ажиллагааг үндсэн зорилгоо болгосон компани байх ёстой ба дараах нөхцөлийг хангасан байна.

1. MOSCAP-ийн 3 ба түүнээс дээш гишүүдийн зохиосон, тус бүр нь 2 оос дээш минутын үргэлжлэх хугацаатай дор хаяж 10 бүтээлийн эрхийг гэрээгээр төлөөлсөн, эсвэл эзэмшсэн байх
 2. Эрх эзэмшиж, төлөөлж буй бүтээлүүд дараах шаардлагыг хангасан байх
- Сүүлийн **1 жилийн** хугацаанд аливаа тоглолт, арга хэмжээ дээр арилжааны зорилгоор дор хаяж 3 удаа тоглогдсон байх;
 - Кинонд бичигдэн бичлэг хийгдсэн байх;
 - Сүүлийн **1 жилийн** хугацаанд аль нэг телевиз **эсвэл** радиогоор дор хаяж 3 удаа нийтэд дамжуулсан байх;
 - Нэг дижитал стриминг **эсвэл** видео платформ дээр арилжааны зорилгоор нийтлэгдсэн бөгөөд дор хаяж 1,000 **сонсолт/үзэлттэй** байх.

Жич: Тухайн бүтээлийн зохиогчтой хийсэн эрх төлөөлүүлэх гэрээний хуулбарыг заавал ирүүлэх (нууцлалтай мэдээллийг халхалж, хасаж болно)

Эрх эзэмшигч/ зохиогч биш гишүүнд тавигдах шаардлага

Дараах Монгол Улсын иргэн, бүртгэлтэй ААН гишүүнээр элсэж болно.

1. Албан үүргийн дагуу туурвисан бүтээлийн ашиглах эрхийг эдлэх ажил олгогч
2. Захиалгаар туурвисан бүтээлийн захиалагч
3. Бүтээл ашиглах онцгой эрхийг гэрээний үндсэн дээр худалдан авсан этгээд

Эзэмшиж буй бүтээлүүд нь дараах шаардлагыг хангасан байх

- Сүүлийн **1 жилийн** хугацаанд олон нийтийн аливаа арга хэмжээ дээр арилжааны зорилгоор дор хаяж 3 удаа тоглогдсон байх;
- Кинонд бичигдэн бичлэг хийгдсэн байх;
- Сүүлийн **1 жилийн** хугацаанд аль нэг телевиз, кабелийн суваг **эсвэл** радиогоор дор хаяж 3 удаа цацагдсан байх;
- Нэг дижитал стриминг **эсвэл** видео платформ дээр арилжааны зорилгоор гаргасан буюу нийтлэгдсэн бөгөөд дор хаяж 1,000 **сонсолт/сонсолттой** байх.

Жич: Тухайн бүтээлийн зохиогчтой хийсэн гэрээний хуулбарыг заавал ирүүлэх (нууцлалтай мэдээллийг халхалж, хасаж болно)

Төлбөр хуваарилах журамтай холбоотой эрхүүд:

Тайлангүй лицензийн орлого, 1 эрх эзэмшигчид 1 жилийн хугацаанд ногдсон маш бага үнийн дүнтэй бүтээл ашиглалтын төлбөрийн нийлбэр дүн, хуваарилах боломжгүй роялти төлбөрүүдийг зөвхөн доорх 3 нөхцөлийг хангасан гишүүдэд хуваарилна.

- Тухайн хуваарилалтын жилд ямар нэгэн бүтээл ашиглалтын төлбөр олсон байх;
- Хоёроос доошгүй жил гишүүн байсан байх.
- Дээрх 2 нөхцлийг хангаагүй удирдах зөвлөлийн гишүүд

Гишүүд өөрийн бүтээлд ногдсон төлбөрийг өөрийн нэр дээрх бус дансаар авах бол хүсэлтээ нийгэмлэгт бичгээр гаргаж гарын үсгээр баталгаажуулна. Гэхдээ зөвхөн өөрийн шууд гэр бүлийн гишүүн, эсхүл харьяалагдах хөгжмийн нийтлэгч Паблишер гишүүний дансанд шилжүүлэх боломжтой.